



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 4/84

Булган сум

“Амар байна уу-2025” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7, 18.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны 25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний уламжлалт цагаан сарын баярыг угтаж орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор “Амар байна уу-2025” үзэсгэлэн худалдааг Булган суманд 2025 оны 02 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Амар байна уу-2025” арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэн худалдаанд сум орон нутгийнхаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг бэлтгэл сайтай өргөн хүрээтэй оролцуулж, зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Давааням)-д даалгасугай.

4. Арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай 2,040,500 (хоёр сая дөчин мянга таван зуу) төгрөгийг “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 17-ний өдрийн 4/104 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

“Амар байна уу-2025” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)

Гишүүд: Д.Алтаншагай (Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга)
Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын дарга)
М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
Т.Хонгорзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
Н.Пүрэвсайхан (Политехникийн коллежийн захирал)
Д.Оюунгэрэл (Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн
танхимын дарга)

Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Ч.Оюун-Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн Үйлдвэрлэл үйлчилгээний
салбарын бодлого зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 20.25 оны
04 дугаар сарын 17-ны/ний өдрийн .../17/ дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

**“Амар байна уу-2025” үзэсгэлэн худалдаа
зохион байгуулахад шаардагдах төсөв**

д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Спортын ордны гадна хананд байрлуулах хаяг	5*4	12000	240 000
2	Дотор хулдаасан хэвлэл	5*3	12000	180 000
3	Эх бэлтгэл, бөгж уяа	2	23250	46 500
4	Сумын хаяг баннер (3м*0.3)	17	10800	183 600
5	Эх бэлтгэл	1	10000	10 000
6	Бөгж	17	1200	20 400
7	Тайз, техник хэрэгсэл зөөх зардал	2	30000	60 000
8	Ширээ сандал зөөх зардал	10	20 000	200 000
9	Тайз засах бусад бэлтгэл ажил	1	100000	100 000
10	Талбайн түрээс, цэвэрлэгээ	1	1000000	1000000
	Нийт			2 040 500